



**МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж 11, Засгийн газрын XI байр,
Утас: 26 09 75, Факс: (976-11) 32 69 75,
E-mail: gecm@gec.gov.mn, <http://www.gec.gov.mn>

2020.01.02 № 02
танай _____-ны № _____-Т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА Г.ЗАНДАНШАТАР ТАНАА**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит
сонгууль **товлон зарлах, санал авах өдрийг тогтоох,**
ээлжит сонгуульд **техник хэрэгсэл хэрэглэх тухай**
Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон
холбогдох мэдээллийг хавсралтаар хүргүүлж
байна.

Хавсралт 17 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Ч.СОДНОМЦЭРЭН

000004

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмжийг тус тус хэрэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг